



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 0/32

Хэрлэн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос үнэгүй 220 тн өвс, хямдруулсан үнээр олгож буй 110 тн тэжээлийг өвөлжилт хүндэрсэн сумдад олгох хуваарийг нэгдүгээр, зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдах зөрчил гаргуулахгүй байх зорилгоор хяналт тавих ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Хоёр: Тусламжаар олгож байгаа үнэгүй өвс, хөнгөлттэй үнээр олгож буй тэжээлийг малчдад хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж 2017 оны 01 дүгээр сарын 10-нд тайланг ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав: Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж удирдлагаар ханган илтгэж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /онцгой байдлын хурандаа Д.Батжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ 08 ДУГААР ТОГТООЛЫН ДАГУУ ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХЭНТИЙ АЙМАГ
 ДАХЬ УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАРААС ҮҮНЭГҮЙ ӨӨВС, ХЯМДАРСАН ТЭЖЭЭЛ ОЛГОХ ХУВААРЬ

Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 03 өдрийн 138 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

№	Цэгийн нэр	Сумдын нэрс		Өвс /2016 он, боодол 4400 төг/			Хивэг /2015 он/ 50хувь хямдарсан			Хивэг/2016 он/50хувь хямдарсан			
		ТН	Боодол	ТН	шуудай	ҮНЭ	ТН	шуудай	ҮНЭ	ТН	шуудай	ҮНЭ	
1	Бэрхийн өөвс тэжээлийн цэг	1	Норовлин	16	800					10	400	2,100,000	
		2	Батноров	16	800					10	400	2,100,000	
		3	Баян-Овоо	16	800					10	400	2,100,000	
		4	Дадал	16	800					10	400	2,100,000	
		5	Баянхутаг	10	500					5	200	1,050,000	
		6	Мөрөн	10	500					5	200	1,050,000	
		7	Өлзийт	6	300					5	200	1,050,000	
		8	Бэрх	12	600					5	200	1,050,000	
		9	Хэрлэн	10,6	530		351	1,901,367					
		10	Онцгой комисс	12	600		400	2,166,800					
		124,6	6230		751	4,068,167				60	2400	12,600,000	
2	Шар талын үүрийн цэг	1	Баян-Адрага	20	1000	6	240	1,261,500					
		2	Өмнөдэлгэр	10	500	6	240	1,261,500					
		3	Биндэр	10	500	6 "	240	1,261,500					
		4	Батширээт	10	500	5	200	1,051,250					
		5	Хурх	10	500	6,15	246	1,293,037.5					
		60	3000	29.15	1166	6,128,787.5							
3	Хэрлэнбаян-Улааны өөвс тэжээлийн цэг	1	Цэнхэрмандал	10	500								
		2	Жаргалтхаан	10	500								
		3	Дэлгэрхаан	8	400						1,0	40	192000
		4	Хэрлэнбаян-Улаан	7,4	370						1,075	43	206400
		35,4	1770						2,075	83	398400		
	Нийт дүн	220	11000	47,925	1917	10,196,954.5			62,075	2483	12,998400		

Аймгийн Засаг даргын 2017 оны ...
дугаар сарын ... өдрийн ... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
дарга:

Д.Батжаргал

-Онцгой байдлын газрын дарга
онцгой байдлын хурандаа

Гишүүд

Л.Бат-Октябрь

-Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

О.Ганбат

-Цагдаагийн газрын дарга,
цагдаагийн хурандаа

Э.Мөнх-Эрдэнэ

-Хөрөнгө оруулалт, Хөгжлийн
бодлогын хэлтсийн дарга

Ж.Энх-Амгалан

-Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Сүнгээ

-Мэргэжлийн хяналтын газрын
дарга